ДУНДГОВЬ АЙМАГ
**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 04 өдөр Дугаар А/05 Хараат

Зарим албан хаагчдын ажлын цагийг богиносгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 28-ны өдрийн 01 албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвар болон томуу, томуу төст өвчний үед болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдыг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажлын цагийн хуваарийг 09.00-12.00, 14.00-17.00 цагийн хооронд мөрдөн богиносгосон цагаар ажиллуулсугай.

2. Засаг даргын Тамгын газрын 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдын судалгааг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтад нэр дурдсан албан хаагчдын богиносгосон цагийг үндсэн цагаар тооцон цалинг бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Цэндмаа)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийгмийн бодлогын мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Батгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА З.СОЛОНГО

ТУ31984 9033599 0820020006

482002014

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын
2020 оны 02 сарын 14 өдрийн А/05 тоот
тушаалын хавсралт

## ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН 0-5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН СУДАЛГАА

2020.02.14

| № | Овог нэр | Албан тушаал | 0-1 нас | 2-3 нас | 4-5 нас | Нийт хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | З.Солонго | ЗДТГ-ын дарга | | 1 | 1 | 2 |
| 2 | Г.Жаргалмаа | Багийн Засаг дарга | 1 | | | 1 |
| 3 | Г.Эрдэнэтуяа | Бичиг хэргийн ажилтан | | 1 | 1 | 2 |
| 4 | З.Анхбаяр | Жолооч | | | 1 | 1 |
| 5 | Ё.Мядагмаа | Санхүүгийн албаны дарга | | | 1 | 1 |
| 6 | З.Батсайхан | Нярав | | | 1 | 1 |
| Нийт хүүхдийн тоо | | | | | | 8 |